Хотын стандарт, хяналтын газрын даргын 2023 оны 03 дугээр сарын 06.-ны өдрийн 01/147 дугаар албан бичгийн хавсралт

9022011029
3314551 CBT17629

Хотын стандарт хяналтын газар

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ гаргах заалт
/ 2023 оны I,II сарын тайлан мэдээ /

| Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | 2023 оны I, II сарын хэрэгжилтийн **үр дүнгийн тухай** мэдээлэл | Хэрэгжилтийн үнэлгээ | | | | | 30 болон 0 үнэлгээтэй бол удаашируулсан шалтгаан | | | Хэрэгжилтийн явц | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 30 | 0 | ХБ | Санхүүжилтээс | Зохион байгуулалтаас | Урт хугацаанд хэрэгжих | Бүрэн хэрэгжсэн | Тодорхой ахиц гарсан | Ажил огт хийгдээгүй |
| | | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | | | | | |
| 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | XX.5. . Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, стандартын талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх, боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар эхний ээлжийн **9** бүлгийн **38** хотын стандартыг баталж 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдүүлэхээр шийдвэрлэсэн.<br><br>Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 17 дугаар хуралдааны тэмдэглэлд Хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, аж ахуй нэгж байгууллагуудад сурталчилан таниулах, сургалт арга зүйгээр хангах зэрэг арга хэмжээг хариуцан салбар, чиг үүргийнхээ хүрээнд 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад үүрэг болгосон.<br><br>2023 онд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, батлагдсан хотын стандартыг | | 70 | | | | | | | | + | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав; | мөрдүүлэх зорилгоор “Хууль, норм дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах ажлын нэгдсэн төлөвлөгөө”-г боловсруулан уг төлөвлөгөөний төсөлд Нийслэлийн нутгийн захиргааны **45** байгууллагад албан бичиг хүргүүлэн санал авч тусган Засаг даргын Зөвлөлийн хуралд 3 дугаар сарын эхний хагаст танилцуулахаар ажиллаж байна.<br><br>Батлагдсан хотын стандартад хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичигт дараах ХОТЫН СТАНДАРТ-ууд хамаарна.<br><br>**Ногоон байгууламж** бүлгийн 5 стандартын баримт бичиг:<br>1. Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлтийн удирдамж<br>2. Мод таримал ургамлын төрөл зүйлийн лавлах /Ургамлын онцлог, тарьж ургуулах аргачлал/<br>3. Ногоон байгууламжийн арчилгаанд тавигдах шаардлага<br>4. Цэцэрлэгчийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны удирдамж<br>5. Цэцэрлэгчийн хөдөлмөрийн багаж хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн лавлах<br>**Иж бүрэн гудамж** бүлгийн 3 стандартын баримт бичиг:<br>1. Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах ерөнхий шаардлага<br>2. Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага<br>3. Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавигдах ерөнхий шаардлага | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтийг хангуулах, зөвлөмж арга зүйгээр хангах, сурталчилан таниулах, холбогдох нутгийн захиргааны байгууллагуудад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах талаар холбогдох зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | | | | | | | | | | | |
| 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47 | IX.1.14. Нийслэл Улаанбаатар хотод оршин суух, явганаар болон дугуйгаар зорчих эрүүл, аюулгүй орчин, боломжийг бүрдүүлэх, хайс, хашааг буулгаж явган замын тасралтгүй байдлыг хангах, сүлжээг одоогийн байгаагаас хоёр дахин нэмэгдүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Иргэдийн эрүүл аюулгүй байдал болон бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэлд судалгаа хийж, эрсдэл учруулж болзошгүй зөрчлийг арилгуулж, хууль тогтоомж, стандарт, норм дүрмийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор холбогдох улсын (ахлах) байцаагчид тус газрын 2023 оны "Хууль, норм дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах ажлын нэгдсэн төлөвлөгөө"-нд дараах заалтыг тусган хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд:<br>– "UCS 0901B Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага", "UCS 0903B Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлага"-ын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх. | | 70 | | | | | | | | + | |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Э.ДАВААХАТАН

БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА,САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН М.ГАЧМАА

9022090260 8314551

Хотын стандарт, хяналтын газар

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ гаргах заалт
/ 2023 оны III сарын тайлан мэдээ /

2023 оны 04 дүгээр сарын 05 Улаанбаатар хот

| Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | 2023 оны III сарын хэрэгжилтийн **үр дүнгийн тухай** мэдээлэл | Хэрэгжилтийн үнэлгээ | | | | | 30 болон 0 үнэлгээтэй бол удааширсан шалтгаан | | | Хэрэгжилтийн явц | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 30 | 0 | ХБ | Санхүүжилтээс | Зохион байгуулалтаас | Урт хугацаанд хэрэгжих | Бүрэн хэрэгжсэн | Тодорхой ахиц гарсан | Ажил огт хийгдээгүй |
| | | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | | | | | |
| 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | XX.5. . Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, стандартын талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх, боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд | Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах ажлын удирдамж, нэгдсэн төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр А/242 дугаар захирамжаар батлуулсан.<br>Төлөвлөгөөнд нийт 126 арга хэмжээ тусгагдсанаас хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын стандартын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж мөрдүүлэх, сурталчлан таниулах чиглэлээр дараах арга хэмжээг тусган УБЗАА болон холбогдох нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран хэрэгжилтийг зохион байгуулахаар ажиллаж байна. Үүнд:<br>Стандарт мөрдүүлэх чиглэлээр:<br>– 25500 м2 явган хүний зам, 48500м2 дугуйн замд хотын стандартын шаардлага хангуулна, | | + | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав; | – Ногоон байгууламжийн арчилгаанд тавигдах шаардлагыг 135 га талбайд хангуулна,<br>– Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн ногоон байгууламжийг арчлан хамгаалах, нөхөн сэргээхэд “UCS 0803B:2022 Ногоон байгууламжийн арчилгаанд тавигдах шаардлага”, “UCS 0802A:2022 Цэцэрлэгчийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны удирдамж” хотын стандартыг мөрдөж ажиллана,<br>– Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээнд “UCS 1704A:2022 Зам талбайн үйлчлэгч, ачигч, тээврийн ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны удирдамж” хотын стандартыг мөрдөж ажиллана,<br>– Зам талбайн үйлчлэгч нарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нормын хувцасны стандартыг хангуулна.<br><br>Сургалтын чиглэлээр:<br>– Хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлан таниулах, сургалт арга зүйгээр хангана. Энэ хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд СХД-ийн ЗДТГ-тай хамтран Нийтийн эзэмшлийн бүлгийн 10, Ногоон байгууламж бүлгийн 5 хотын стандартыг танилцуулж дүүргийн албан хаагч, ААНБ-ын төлөөлөл нийт 130 гаруй иргэдэд сургалт зохион байгуулсан.<br><br>Хяналт шалгалтын чиглэлээр:<br>– UCS 0901B Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага”, “UCS 0903B Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлага”-ын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийхээр ажиллаж байна.<br>Дээрх нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүүрэг бүрд | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хариуцан хэрэгжүүлэх нийт 29 албан хаагчийг газрын даргын 2023 оны А/20 дугаар тушаалаар томилсон. | | | | | | | | | | | |
| 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47 | IX.1.14. Нийслэл Улаанбаатар хотод оршин суух, явганаар болон дугуйгаар зорчих эрүүл, аюулгүй орчин, боломжийг бүрдүүлэх, , сүлжээг одоогийн байгаагаас хоёр дахин нэмэгдүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Иргэдийн эрүүл аюулгүй байдал болон бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэлд судалгаа хийж, эрсдэл учруулж болзошгүй зөрчлийг арилгуулж, хууль тогтоомж, стандарт, норм дүрмийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжаар батлагдсан нэгдсэн төлөвлөгөөгөөр дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:<br>– Батлагдсан хотын стандарт болох “UCS 0901B Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага”, “UCS 0903B Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлага”-ын дагуу хайс, хашааг буулгаж явган замын тасралтгүй байдлыг хангах ажлыг УБЗАА, дүүргүүдийн ЗДТГ-тай хамтран холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>– НЗД-ын 2023 оны А/323 дугаар захирамжаар газар ашиглалтыг сайжруулах, явган зам, талбайн хүрэлцээг нэмэгдүүлэх, зөвшөөрөлгүйгээр хашаа, хайс барьсан зөрчлийг арилгах, чөлөөлөх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажлын хэсгийн хуралд оролцон ажиллаж байна. | | + | | | | | | | | | |

---oOo---